

МОНГОЛЫН ТАЕКВОНДОГИЙН ХОЛБООНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэгдүгээр зүйл. Зорилго

1.1 Биеийн тамир, спортын тухай хууль, холбогдох бусад олон улсын болон Үндэсний эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг баримтлан Монголын Таеквондогийн Холбоо /цаашид “Холбоо” гэх/ зорилго чиглэлийн хүрээнд зохион байгуулж байгаа олон талт үйл ажиллагаанд оролцож буй тамирчин, дасгалжуулагч, шүүгч болон таеквондогийн спортыг хөгжүүлэх үйлсэд хувь нэмэр оруулж байгаа бусад багш, мэргэжилтэн, хувь хүний баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлэхэд энэхүү дүрмийн зорилго оршино.

Хоёрдугаар зүйл. Хамрах хүрээ

2.1 Энэхүү дүрэм нь дараах үйл ажиллагаа эрхэлж байгаа тамирчин, дасгалжуулагч, шүүгч, багийн ахлагч, бусад багш, мэргэжилтэн, хувь хүн түүнчлэн клуб, салбар холбоо зэрэг хуулийн этгээдэд хамаарна. Үүнд:

- 2.1.1 Олон улсын хэмжээнд зохиогдож буй таеквондогийн тэмцээн, наадамд Монгол улсын нэрийн өмнөөс оролцож байгаа;
- 2.1.2 Дотоодод зохиогдож буй таеквондогийн тэмцээн, наадамд оролцож байгаа;
- 2.1.3 Бэлтгэл, цугларалт, нийтийг хамарсан бүх төрлийн спортын баяр ёслол, хурал зөвлөгөөн, сургалт, бусад арга хэмжээнд тус тус оролцож байгаа;
- 2.1.4 Таеквондогийн спортыг хөгжүүлэх, дэлгэрүүлэх чиглэлээр секц, клуб хичээллүүлж байгаа;

Гуравдугаар зүйл. Зарчим

3.1 Энэхүү дүрмийн 2.1-т заасан этгээдүүд нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлана.

- 3.1.1 Спортын шударга өрсөлдөөнийг эрхэмлэх
- 3.1.2 Хүнлэг, энэрэнгүй байх
- 3.1.3 Шударга ёсыг сахих
- 3.1.4 Хууль дээдлэх

3.1.5 Соёлтой харилцааг эрхэмлэх

3.1.6 Бусдын хуулиар хамгаалагдсан нэр төр, алдар хүндийг хүндэтгэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЁС ЗҮЙН ҮНДСЭН ХЭМ ХЭМЖЭЭ

Дөрөвдүгээр зүйл. Эрхэм зэрэг

4.1 Үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндээр нь ялгаварлан гадуурхаж үл болно.

4.2 Бусдын эсрэг биеийн, сэтгэл санааны, мэргэжлийн түүнчлэн бэлгийн дарамт үзүүлэх нь хориотой.

Тавдугаар зүйл. Нэгдмэл байдал

5.1 Аливаа этгээд нь тэмцээн, наадамтай холбоотойгоор ямарваа нэгэн шан харамж бусад санхүүгийн үр ашиг үйлчилгээг шаардах, хүлээн авах эсвэл санал болгох хориотой.

5.2 Талархал, эсвэл нөхөрлөлийн хүрээнд тухайн орон нутгийн ёс заншилд нийцэх бага үнэлгээтэй бэлэгийг хүлээн авч болно.

5.3 Аливаа этгээд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна. Хэрэв ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдал бий болсон бол энэ тухайн Холбооны эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.

5.4 Аливаа этгээд нь өөр хоорондоо болон бусадтай ямагт хүндэтгэлтэй, зөв боловсон харьцана.

Зургаадугаар зүйл. Нөөц

6.1 Таеквондогийн аварга шалгаруулах бүх түвшний тэмцээнийг зөвхөн Холбоо болон түүнээс эрх олгосон этгээд зохион байгуулах эрхтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТАМИРЧНЫ МӨРДӨХ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Долоодугаар зүйл. Тэмцээний үед тамирчны мөрдөх ёс зүйн хэм хэмжээ

7.1 Тамирчны нэрийг дуудсаны дараа дасгалжуулагчийн хамт дэвжээний дэргэд ирэх ба үзэгчдийн өмнө хувцсаа тайлах, сурталчилгааны болон суудлын хашлага давах, зориулалтын бус газраар орж, гарахгүй байх.

7.2 Тамирчны үг, үйлдэл нь бусдад таеквондогийн спортоор бахархах сэтгэгдлийг төрүүлэхүйц байна.

7.3 Тамирчин нь тулаан эхлэх болон дуусах үед тэмцээнийг шүүх шүүгч болон өрсөлдөгч тамирчин түүний дасгалжуулагчид хүндэтгэл үзүүлэн ёсолж, тулаан дууссаны дараа өрсөлдөгч тамирчин болон түүний дасгалжуулагчтай гар барьж хүндэтгэл үзүүлэх ёстой.

7.4 Тулааны үеэр тамирчид хоорондоо болон шүүгчтэй ярих, маргахыг хориглоно.

7.5 Эмнэлгийн магадлагаанаас бусад шалтгаанаар тамирчин тулалдахаас татгалзах эрхгүй. Хэрэв ийм байдал гаргавал тэмцээнээс багаар нь хасах бөгөөд байр эзлүүлэхгүй.

7.6 Дэвжээнд гарахаас болон шагналын тавцанд гарахаас саналаараа татгалзсан тамирчныг болон тухайн тамирчны багийг тэмцээнээс хасч байр эзлүүлэхгүй.

7.7 Тамирчин нь шүүгчийг хүндэтгэн түүнд захирагдан дүрмийн дагуу тавьсан шаардлагыг даруй биелүүлнэ. Шүүгчийг доромжлох, дарамтлах, ёс бусаар харьцах, тэдний эрх чөлөөнд халдаж үл болно.

7.8 Тамирчин нь тэмцээнд оролцогчийн мандат авахаас өмнө дэвжээний хураамжаа бүрэн төлсөн байна. Хураамж төлөөгүй тохиолдолд тэмцээнд оролцох эрхийн мандат олгохгүй төдийгүй тэмцээнд оролцох эрхгүй болно.

Наймдугаар зүйл. Тамирчны цээрлэх зүйл

8.1 Тамирчин нь бэлтгэл, цугларалт, тэмцээний үеэр мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэж архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, бусдыг заналхийлэх, зодох, хэл амаар доромжлохыг хориглоно.

8.2 Өрсөлдөгчдөө санаатайгаар бууж өгөхийг хориглоно.

8.3 Өрсөлдөгчөө санаатайгаар гэмтээсэн болон гэмтээхийг оролдсон, хориглосон өшиглөлт, цохилт хэрэглэх, гэмтэл учруулахыг хориглоно.

8.4 Хориглосон болон допингийн төрлийн эм бэлдмэл хэрэглэхийг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БАГИЙН АХЛАГЧ, ДАСГАЛЖУУЛАГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Ес дүгээр зүйл. Багийн ахлагч, дасгалжуулагчийн ёс зүйн хэм хэмжээ

9.1 Тэмцээнд оролцогчдын мандат авахаас өмнө багийн ахлагч болон дасгалжуулагч холбооны санхүүгын журмын дагуу аливаа хураамжийг бүрэн төлж дуусгасан байна.

9.2 Дасгалжуулагч, багийн ахлагч нар тэмцээний туршид бэлтгэлийн хувцас эсвэл албаны хувцастай байна.

9.3 Тэмцээний үед дасгалжуулагч, багийн ахлагч нь тэмцээний байранд байх бөгөөд шалтгаангүйгээр тэмцээнийг орхиж явахыг хориглоно.

9.4 Дасгалжуулагч нь тэмцээний явцад шүүгч нартай ярих, маргах, үйл ажиллагаанд саад хийх, шийдвэр гаргахад шахалт үзүүлэхийг хориглоно.

9.5 Багийн дасгалжуулагч, ахлагч нь өөрийн болон аливаа тамирчныг доромжлох, тэдэнтэй зүйл бусаар харьцах, нийтийг үл хүндэтгэн бусдын бие, эрх чөлөөнд халдахыг хориглоно.

9.6 Шүүгчийн шийдвэрийг эсэргүүцэн өөрийн санал, гомдлыг ганцаар болон бусдыг уриалсан олон нийтийн дунд зүй бусаар илэрхийлэхийг тамирчин, дасгалжуулагч, багийн ахлагч нарт хатуу хориглоно.

9.7 Тэмцээний шүүлттэй холбоотой аливаа маргааныг зөвхөн тэмцээнийг зохион байгуулагч эсвэл холбооны шүүгчдийн зөвлөлийн даргад албан бичгээр, баримтын хамт уламжилж тухайн асуудлыг шийдвэрлүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Аравдугаар зүйл. Шүүгчийн ёс зүйн үндсэн хэм хэмжээ

10.1 Шүүгч нь шүүгчдийн зөвлөл буюу ерөнхий шүүгчийн удирдлага дор ажиллаж, өөр хоорондоо хүндэтгэлтэйгээр харьцаж, тавьсан шаардлага, зөвлөмжийг чанд сахин биелүүлнэ.

10.2 Шүүгч нь тэмцээний үед бие даасан, хараат бус байж, зөвхөн өөрийн хүлээсэн үүргийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.

10.3 Шүүгч тэмцээнийг шүүхдээ аль нэг тамирчин, дасгалжуулагч, багийг дэмжих хандлага, үйлдэл гаргахыг хориглоно.

10.4 Шүүгч нь тамирчдад заавар, зөвлөгөө өгөх, хашгирахыг хатуу хориглоно.

10.5 Дэвжээний голын болон хажуугийн шүүгч нь ахлах шүүгч дуудаагүй үед түүний ширээнд ойртохыг хориглоно.

10.6 Тухайн тэмцээний үеэр шүүлтийн маргаан гарсан тохиолдолд тухайн дэвжээний ерөнхий шүүгч нь дэвжээний хажуу болон дэвжээний голын шүүгчийг өөрийн ширээнд урьсаны дараа дүрмийн заалтын дагуу зөвлөлдөх, эсвэл шүүгчдийн зөвлөлийн даргатай зөвлөлдөж маргааныг тэр дор нь шийдвэрлэнэ.

10.7 Мэргэжлийн алдаа дутагдал гаргаж аливаа тамирчин, баг хамт олныг хохироож үл болно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

БУСАД

Арван нэгдүгээр зүйл. Сахилгын хариуцлага

11.1 Аливаа этгээд нь дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээг биелүүлээгүй, зөрчсөн, зөрчихийг завдсан тохиолдолд сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

Сахилгын хариуцлага хүлээлгэх журмыг Сахилгын дүрмээр тодорхойлно.

Арван хоёрдугаар зүйл. Хүчин төгөлдөр болох

12.1 Энэ дүрмийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛЫН ТАЕКВОНДОГИЙН ХОЛБОО